

МОН-ИТ БУЛИГААР ХК



**БУЛИГААР**

BOVINE SKIN TANNERY

EST. 1934

---

ХАГАС ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН

**2021**

## 01

Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл Хуудас 2-7

## 02

Удирдлагын талаарх мэдээлэл Хуудас 8-9

## 03

Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл Хуудас 10-11

## 04

Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл Хуудас 12-13

## 05

Ногдол ашгийн талаарх мэдээлэл Хуудас 13

# КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

---

Компанийн оноосон нэр	Мон-Ит Булигаар ХК
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга: А.Энхмэнд Гүйцэтгэх захирал: Б.Анхболд
Үүсгэн байгуулагдсан он	1934
Үйл ажиллагааны чиглэл	Арьс шир боловсруулалт, худалдаан борлуулах, гадаад худалдаа
Хүчин чадал	500,000 ширхэг буюу 7500 тн арьс, шир боловсруулах 1,300,000 кв.м боловсруулсан арьс үйлдвэрлэх 250,000 кв.м боловсруулсан хуулдас илгэ үйлдвэрлэх
Ажилтнуудын тоо	65

# 01. КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

## БИДНИЙ 2021 ОНЫ ЗОРИЛТ



1.

Компанийн хэмжээнд нийт ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, мэргэжлийн ажилтнуудын тогтвор суурьшилийг нэмэгдүүлэх

Цар тахлын үеийн бодлогод онцгой анхаарал хандуулж, ажилтнуудын аюулгүй байдлыг ханган, халдвар хамгааллын дэглэмжийг чанд мөрдөн ажиллаж байна. Үйлдвэрлэлийн тасралтгүй жигд ажиллагааг хангахын тулд гаднын томоохон компаниудтай хамтран мэргэжилтний сургалт хөтөлбөр зохион байгуулахаар ажиллаж байна.



2.

Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар үйлдвэрийн хүчин чадал ашиглалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн тасралтгүй жигд ажиллагааг хангаж ажиллах

Үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтыг нэмэгдүүлэн шинэ бүтээгдэхүүн зах зээлд гарган ажиллаж байна. Дэлгэрэнгүйг хуудас 5,6-аас харна уу.



3.

Экспортоо нэмэгдүүлэх. Нэмүү өртөг шингээж Испани, Турк, Энэтхэг, БНХАУ зэрэг орнууд руу үхрийн арьсыг крастын түвшинд экспортлох

Тайлант хугацаанд Турк, БНХАУ зэрэг улс руу хонь болон ямааны арьсыг wet-blue түвшинд боловсруулан экспортолж байна.



#### 4.

MNS 6561:2015 стандартыг хангасан цэвэрлэх байгууламжийг лабораторийн хамт барьж байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх сайжруулах, MNS 6561:2015 стандартын дагуу чанар аюулгүй байдлыг хангах

MNS 6561:2015 стандартыг хангасан цэвэрлэх байгууламжийг лабораторийн хамт барьж байгуулах угсралтын ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд уг ажлын хүрээнд цэвэрлэх байгууламжийн угсралтын зураг, суурийн болон гүйцэтгэлийн зургийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, байгууламжийн суурийн угсралтыг ажил хийгдэж байна.



#### 5.

Харилцагч руу чиглэсэн маркетинг хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулах, харилцагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Нийт харилцагч нартаа зориулж бүтээгдэхүүн худалдан авах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор санхүүгийн байгууллагатай хамтран компанийн зүгээс хөнгөлөлттэй нөхцөлөөр тодорхой хугацааны зээлийн хүүг бууруулах замаар харилцагч нартаа зээлийн шугам үйлчилгээг авах боломжоор хангаж ажиллаж байна. Харилцагч нарын бизнесийн онцлогоос шалтгаалан тэдэнд улирлын чанартай эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг санүүжүүлэх шаардлага байнга гардаг. Энэ үед нь тэдний мөнгөн урсгалын шаардлагад уялдуулан уг боломжийг бидний зүгээс олгож байгаа.

## САЛБАРТ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2000 оноос арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа сэргэж өнөөгийн байдлаар Улаанбаатар, Дархан хотод арьс шир боловсруулах 34 үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 100 гаруй жижиг, дунд үйлдвэрүүд нийслэл, аймаг орон нутагт ажиллаж байна. Бүтцийн хувьд арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн салбарт арьс ширийг хагас боловсруулах 14, гүн боловсруулах хуурай цех 4, гүн боловсруулах жижиг үйлдвэр 12, гүн боловсруулах том үйлдвэр 10, завод ноос, ноолуур угаах 6 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна.

### Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн бүтэц



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалтын газар, 2020 он

Мон-Ит Булигаар ХК нь үйлдвэрлэл болон тоног төхөөрөмж, хүчин чадлын хувьд салбартаа тэргүүлэгч байгууллагуудын нэг юм. Бид 17,000 м.кв талбай бүхий 6 давхар үйлдвэрлэл, оффисийн барилга болон 3,800 м.кв талбайтай химийн боловруулах цехэд олон улсын арьс ширний үйлдвэрлэлийн салбарт ашиглагдаж буй дэвшилтэт техник технологи бүхий “BILLERI”, “OMACA”, “INCOMA”, “CARLESSI”, “FLAMAR”, “CEMATA”, “MOSTARDINI” зэрэг фирмийн 50 гаруй машин, тоног төхөөрөмжүүдийг ашиглан үйл ажиллагаа явуулж байна.



**Манай үйлдвэр нь хагас болон эцсийн боловсруулалт хийсэн бод, богийн арьс жилд 500,000 ш-ийг боловсруулах буюу 1,300,000 квадрат метр эцсийн боловсруулалт хийсэн арьс, шир, 2.2 сая богийн арьсыг гүн боловсруулах хүчин чадалтай.**

## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Боловсруулсан арьс, ширний зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх компанийн голлох стратегийн хүрээнд шинэ төрлийн бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд анхааран ажиллав.



Тухайлбал, арьсанд хээ тавих зориулалттай 1.0\*1.37 хэмжээтэй embossing plate шинээр худалдан авсан. Уг хээгээр арласан арьсыг ажлын гутлын зориулалтаар голдуу захиалан худалдан авч байгаа.

Түүнчлэн дотоодын зах зээлд энгийн болон ус нэвтрэхгүй хөдөлмөр хамгааллын гутлын зориулалттай болон гоёлын гутлын арьсыг түлхүү бэлтгэн нийлүүлж байна.

Одоогийн байдлаар манай компани нь гутал, хувцас, цүнх, бүс, жижиг эдлэл гэх мэт бүх төрлийн бэлэн бүтээгдэхүүний зориулалттай арьсыг хэрэглэгчийн хүссэн өнгө, зузаанаар бэлтгэн нийлүүлэх техникийн хүчин чадалтай болсон.




---

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

2021 оны хагас жилийн байдлаар шинэ цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах угсралтын ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд уг ажлын хүрээнд цэвэрлэх байгууламжийн угсралтын зураг, суурийн болон гүйцэтгэлийн зургийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, байгууламжийн суурийн ажилд явагдаж байна.

Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, барилгын шинэчлэлт, үйл ажиллагаагаа сайжруулахад дотоод нөөц бололцоондоо тулгуурлан томоохон ажлууд хийсэн.

Үүнээс дурдвал, үхрийн арьсыг зөөлрүүлэн талхих зориулалттай Sprun маркийн Tannery machine тоног төхөөрөмж /1 ширхэг/-ийг шинээр худалдан авсан. Ингэснээр ажлын гутлын зориулалтаар үйлдвэрлэх арьсны эдэлгээг уртасгах, бүх төрлийн бодийн арьс боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанарт ахиц гарах юм.



### Экспортын тойм:

Мон-Ит Булигаар ХК нь экспортын зах зээлийн өсөлтийг эрчимжүүлэн гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар Монгол улсын эдийн засагт хувь нэмэр оруулахад онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Манай үйлдвэрийн хувьд өнөөдрийн байдлаар Турк, БНХАУ зэрэг улс руу хонь болон ямааны арьсыг wet-blue түвшинд боловсруулан экспортолж байна.

### Барилга, байгууламжийн бүтээн байгуулалт:

Барилга байгууламжид гадна болон дотор талд дараах засварын ажлуудыг хийсэн.

- 108 м.кв хэмжээтэй лабораторийн зориулалтаар ашиглах өрөөнүүдийг бүрэн засварласан.

- Барилгын гадна тохижилтыг иж бүрэн тохижуулан засварласан. Үүнд: 310 ш авто хашлага бүхий 900 м.кв авто зам, 580 ш явган хашлага бүхий 150 м.кв явган хүний зам, 550 м.кв автомашины зогсоол, 265 м.кв ногоон байгууламж, 3\*3 хэмжээтэй сүүдрэвч, барилгын үүдэн хэсгийн 20 м.кв-д чулуу нааж тохижуулсан. Мөн үйлдвэр, оффисын барилгын 180 м гадна хаяавч хийсэн.



---

Үйлдвэрлэл, оффисын барилга өмнө нь:



Үйлдвэрлэл, оффисын барилгын гадна засвар болон гадаа тохижилт хийгдсэний дараа нь:



Дээрх засварт зарцуулсан хөрөнгө оруулалт бол зөвхөн барилга байгууламжийн хувьд үйлдвэрлэл хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй ажилтнуудыг ая тухтай орчинд ажиллах боломжтой болгосон.

## 02. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны хагас жилийн байдлаар компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

#### ЕРДИЙН ГИШҮҮНД:

Овог нэр	Мэргэжил	Хашиж буй албан тушаал
Батчулууны АНХБОЛД	Худалдааны эдийн засагч, Мэдээлэл зүйч	Мон-Ит Булигаар ХК, Гүйцэтгэх захирал
Анхболдын ЭНХМЭНД	Хөрөнгө оруулалтын санхүүч	Лугати ХХК, Гүйцэтгэх захирал
Батчулууны БАЯНЖАРГАЛ	Эдийн засагч	Дархан Минж ХХК, Гүйцэтгэх захирал
Довжидын ГАНСҮХ	Барилгын технологич	Мон-Ит Булигаар ХК, Үйлдвэрлэл хариуцсан захирал
Мэндбаярын БАТ-ОЧИР	Арьс ширний үйлдвэрийн инженер технологич, химич	Мон-Ит Булигаар ХК, Үйлдвэрлэлийн зөвлөх

#### ХАРААТ БУС ГИШҮҮНД:

Овог нэр	Мэргэжил	Хашиж буй албан тушаал
Норолхоожавын БАТХУЯГ	Бизнесийн удирдлага	МХС ТӨХК, Газрын захирал
Нүрэнзэдийн МЯГМАРДОРЖ	Бизнесийн удирдлага	Пример Инвестмент Групп ХХК, Гүйцэтгэх захирал
Цэнд-Аюушийн БАЯРСАЙХАН	Техникийн ухааны Ph.D доктор	ШУТИС-ийн Механик Тээврийн Сургуулийн Механик, Мехатроникийн салбарт дэд профессор
Хүрэлбаатарын ГАНБОЛД	Барилгын материалын технологич	Минж Проперти ХХК, Гүйцэтгэх захирал

## КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

Овог нэр	Албан тушаал	Ажлын туршлага
Батчулууны АНХБОЛД	Гүйцэтгэх захирал	МУИСургуулийн Эдийн засгийн сургуульд Мэдээлэл зүйн багш, Санком ҮЦК ХХК-д Диллер, Дархан Минж ХХК-д Ерөнхий захирал  2019 оны 7 дугаар сараас Мон-Ит Булигаар ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
Довжидын ГАНСҮХ	Үйлдвэрлэл хариуцсан захирал	ТТҮБ траст ХХК-д Барилгын даамал, Зэндмэнэ инвест ХХК-д Технологич, Дархан Минж ХХК-д Үйлдвэрлэл хариуцсан захирал, Сүлд Ивээл Констракшн ХХК-д Захирал  2019 оны 7 дугаар сараас Мон-Ит Булигаар ХК-ийн Үйлдвэрлэл хариуцсан захирлаар ажиллаж байна.
Хүчитбаатарын ЛХАГВАСҮРЭН	Ерөнхий нягтлан бодогч	Апу трейдинг ХХК-д Нягтлан бодогч, Гофро ХХК-д Нягтлан бодогч,  2021 оны 5 дугаар сараас Мон-Ит Булигаар ХК-ийн Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна.

### 03. САНХҮҮГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

COVID 19 цар тахалтай холбоотойгоор харилцагчийн төлбөрийн чадвар муудаж, борлуулалтын авлагын хэмжээ нэмэгдсэн. Бидний зүгээс зээлийн борлуулалтын хяналтыг чангатгах, найдваргүй авлагыг бууруулах арга хэмжээ авч ажилласан.

Тайлант хугацаанд нийт хөрөнгийн дүн 17,790 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 36,8 хувь, эргэлтийн бус хөрөнгө 63,1 хувийг тус тус эзэлж байна.

Эзэмшигчдийн өмч оны эхэнд 6,487 сая төгрөг байсан бол 2021 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар 6,156 сая төгрөг болсон нь хуримтлагдсан алдагдал өссөнтэй холбоотой байна.

#### Санхүүгийн байдлын тайлан:

(сая. төгрөгөөр)

	2020.12.31	2021.06.30
		Аудитлагдаагүй
Эргэлтийн хөрөнгө	6,134	6,559
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,477	11,231
<b>Нийт хөрөнгө</b>	<b>17,611</b>	<b>17,790</b>
Өр төлбөрийн нийт дүн	11,123	11,633
Эзэмшигчдийн өмчийн дүн	6,487	6,156
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>17,611</b>	<b>17,790</b>

#### Орлогын тайлан:

Борлуулалтын орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 3 дахин өсөлттэй, тайлант хугацаанд 2020 оны борлуулалтын орлогын 70%-д хүрсэн байна.

(сая. төгрөгөөр)

	2020.12.31	2021.06.30
		Аудитлагдаагүй
Борлуулалтын орлого (цэвэр)	2,965	2,099
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,429	2,043
<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>(464)</b>	<b>56</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(1,433)</b>	<b>(330)</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(1,438)</b>	<b>(330)</b>

---

## ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

## СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Доорх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд нь зах зээлийн нөхцөлөөр хийгдсэн болно.

(мян. төг)

<b>Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ</b>	<b>2021-06-30</b>
---	-------------------

Холбоотой талтай хийсэн борлуулалт	793,273
------------------------------------	---------

Холбоотой талаас авсан худалдан авалт	971,258
---------------------------------------	---------

## САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд нэмж авсан зээлийн байхгүй болно.

(мян. төг)

<b>Банкны нэр</b>	<b>2020-12-31</b>	<b>2021-06-30</b>
-------------------	-------------------	-------------------

Капитрон банк	5,807,147	5,763,801
---------------	-----------	-----------

## 04. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

---

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Мон-Ит Буигаар ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

#### Ээлжит хурал:

Мон-Ит Буигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 14:00 цагт зохион байгуулагдав. Дэлхий даяар үүссэн нөхцөл байдал, COVID 19-тэй холбоотой хөл хорионы улмаас Мон-Ит Булигаар ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа анх удаа цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. Хуралд 88.1 хувийн саналын эрхтэй нийт 4 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан бөгөөд нийт 2 асуудлыг хэлэлцэж батлав.

*Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн Мон-Ит Буигаар ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 100%-ийн саналаар батлав.*

*Хоёр. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг олонхын саналаар батлав.*

## 05. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт гараагүй болно. Мон-Ит Булигаар ХК нь нийт 400,212 ширхэг үнэт цаасны 352,626 ширхэг буюу 88.11%-ийг дараах нэр бүхий хувьцаа эзэмшигчид нь эзэмшдэг болно. Үүнд:

Хувьцаа эзэмшигч	Тоо ширхэг	Хувь
А.Энхмэнд	156,630	39.14%
Б.Анхболд	145,996	36.48%
Б.Баянжаргал	50,000	12.49%
Бусад	47,586	11.89%
<b>Нийт дүн</b>	<b>400,212</b>	

### НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Компани нь 2020 оны санхүүгийн жилд нийт 1,433,554,600 төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилаагүй болно.

## Компанийн албан ёсны хаяг

Монгол улс, Улаанбаатар хот - 17042,  
Хан-Уул дүүрэг, 11-р хороо,  
Мон-Ит Булигаар ХК

Утас: (976)-99097216  
И-мэйл: buligaar1934@gmail.com  
Фэйсбүүк: Mon-It Buligaar JSC